

**АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТӨСӨЛД ЗАСГИЙН ГАЗРЫН ГИШҮҮД, ЗАРИМ БАЙГУУЛЛАГААС ИРҮҮЛСЭН САНАЛ**

2017.04.06

Д/д	Байгууллага, албан тушаалтан	Ирүүлсэн санал
1.	Монгол Улсын Шадар сайд	Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний төсөл болон Засгийн газрын тогтоолын төсөлд тусгайлан өгөх саналгүй болно.
2.	Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга	<p>Уг төлөвлөгөөний төслийг зарчмын хувьд дэмжиж, дараах саналыг хүргүүлж байна:</p> <p>1. Улсын Их Хурлын 2016 оны 51 дүгээр тогтоолоор батлагдсан Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр нь 2016-2019 он, 2019-2023 он гэсэн хоёр үе шаттайгаар 6 жилийн хугацаанд хэрэгжихээр батлагджээ. Танайхаас боловсруулж, санал авахаар ирүүлсэн Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний төсөл нь дээрх хөтөлбөрт заасан үе шат бүрээр хэрэгжүүлж, үр дүнг нь үнэлэх байдлаар боловсруулагдаагүй байна.</p> <p>2. Монгол Улсын 2017 оны төсвийн тухай, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2017 оны мэдэгдэл, 2018-2019 оны төсвийн төсөөллийн тухай хуулиудтай уялдуулан нэгдүгээр үе шатыг хэрэгжүүлэхэд шаардагдах арга хэмжээний төсөв, хөрөнгийг тодорхой заах.</p> <p>3. Төсөлд заасан хэрэгжүүлэх арга хэмжээний хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлтийг Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрт тусгасан үе шат, хүрэх үр дүнд нийцүүлж, уялдуулах. Тухайлбал, зорилт 2-ын хүрээнд төрийн үйлчилгээг иргэнд цахим хэлбэрээр хүргэх тогтолцоог бүрдүүлэх, цахим үйлчилгээний нэгдсэн сүлжээ бий болгож бүрдүүлэх үйл ажиллагааг, мөн зорилт 6-ын хүрээнд төр хувийн хэвшлийн хамтын түншлэлийн заагийг тодорхойлох зэрэг үйл ажиллагааг нэгдүгээр үе шатанд хэрэгжүүлэхээр тусгах.</p> <p>4. Төлөвлөгөөний төсөлд хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлтийг тусгахдаа Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 17.1.4-т хөгжлийн бодлогын баримт бичгийн төслийг оновчтой бодлогын хувилбарт үндэслэн зорилго, зорилт, хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлт, хэрэгжүүлэх арга зам, үе шат, түүнд шаардлагатай нөөцийг нарийвчлан төлөвлөж боловсруулахаар, Засгийн газрын 2016 оны 249 дүгээр тогтоолоор батлагдсан “Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журам”-ын 9.9-д шалгуур үзүүлэлт гэж хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үе шат бүрт бий болох өөрчлөлтийг хэмжихээр төсөлд заасан чанарын болон тоон үзүүлэлтийг хэлэхээр тус тус заасантай нийцүүлэх. Тухайлбал, зорилт 1-ийн хүрээнд төрийн албаны зөвлөл болон салбар зөвлөлийн дүгнэлт, хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хяналгүйгээр томилгоо хийсэн албан тушаалтанд хүлээлгэх хариуцлагыг тодорхой болгох арга хэмжээний хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлтийг томилгоотой холбоотой шийдвэрт судалгаа хийх, үнэлэлт дүгнэлт өгөх, хууль тогтоомжийн төсөл боловсруулах гэх мэт байдлаар хэрэгжүүлэх арга хэмжээг тусгаж байгааг анхаарах</p> <p>5. Арга хэмжээг хэрэгжүүлэх үндсэн байгууллагыг тодорхой тусгах. Тухайлбал, зорилт 5-ын хүрээнд зөвшөөрөл олгох журмыг хялбарчилж түүнд тавих хяналтын тогтолцоог бүрдүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх үндсэн, хамтрагч, оролцогч байгууллагууд тодорхойгүй байна.</p> <p>6. Хууль тогтоомжид заасан чиг үүргийн хүрээнд хамаарах байгууллага тухайн арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгах. Тухайлбал, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын хуулиар хүлээсэн үүрэгт үл хамаарах дараах арга, хэмжээг хэрэгжүүлэхээр заасан байгааг эргэж хянах:</p> <ul style="list-style-type: none"> - зорилт 1-ийн хүрээнд нийтийн албан тушаалтанд холбогдох авлига, ашиг сонирхол, ёс зүйтэй холбоотой өргөдөл, гомдол, мэдээллийг хүлээн авах, хянан шалгах, хариуцлага хүлээлгэх үйл ажиллагааг шинэ арга хэлбэрт шилжүүлэх, дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлэх; - зорилт 2-ын хүрээнд олон улсын стандарт хангасан бараа, бүтээгдэхүүнийг дотоодын стандартаар шалгадаг зохицуулалтыг өөрчлөх, шаардлагагүй стандартыг хүчингүй болгох;

		<ul style="list-style-type: none"> - зорилт 3-ын хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээ бүхэлдээ; - зорилт 6-ын хүрээнд төрийн байгууллага, хувийн хэвшлийн хооронд байгуулах аливаа гэрээ, хэлэлцээрт авлигын эрсдлээс хамгаалах талаар тусгаж байх зохион байгуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлэх; - зорилт 8-ын хүрээнд Хэвлэл мэдээллийн зөвлөлийн үйл ажиллагааны зохих зардлыг /100,0 сая/ төсвийн санхүүжүүлттэй болгох, санхүүжилтийн холимог системийг хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх; - зорилт 10-ын хүрээнд авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, ёс зүй, ил тод байдлыг сайжруулах, хүнд суртал, чирэгдлийг арилгах чиглэлээр дотоодын сайн туршлага, оновчтой шийдлийг сурталчлах, түгээх, нэвтрүүлэх ажлыг зохион байгуулах; <p>7. зорилт 11-ийн хүрээнд эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх хүсэлт, даалгавар, бусад нэмэлт материалыг орчуулахад шаардлагатай хөрөнгийн асуудлыг шийдвэрлэх, шаардлагатай тохиолдолд орон тоог зохих байгууллагад бий болгох.</p> <p>8. “Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журам батлах тухай” Засгийн газрын 2016 оны 249 дүгээр тогтоолд заасны дагуу хэрэгжүүлэх байгууллагыг хэрэгжилтийг хангах хариуцлагын эрэмбээр жагсаах. Тухайлбал, зорилт 6-ын хүрээнд төр, хувийн хэвшлийн түншлэлийн талаарх эрх зүйн зохицуулалтыг бий болгох, хувийн хэвшилд төрийн ажил, үйлчилгээг шилжүүлэхэд тавигдах, шаардлага, нөхцөл, хариуцлагын талаарх эрх зүйн орчинг бүрдүүлэх, Төрийн болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, үйлдвэрийн газрын эрхэлж байгаа аж ахуйн үйл ажиллагаа болон зарим төрлийн зөвшөөрөл, бүртгэл, эрх олгох үйл ажиллагааг хувийн хэвшилд шилжүүлэх ажлыг судлан, шилжүүлж болох үйлчилгээний жагсаалт гаргах зэрэг арга хэмжээг хэрэгжүүлэх үндсэн байгууллагыг Үндэсний хөгжлийн газар, Засгийн газар Хэрэг эрхлэх газар гэсэн байдлаар тусгах.</p> <p>9. Засгийн газрын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр төсөлд заах. Тухайлбал, зорилт 10-ын хүрээнд хэвлэл мэдээллийн байгууллага авлигын аливаа хэлбэрийг үл тэвчих нийгмийн сэтгэл зүйн орчинг төлөвшүүлэхэд нийтлэл, нэвтрүүлгийнхээ бодлогыг чиглүүлэх, энэ талаар байнга мэдээлэл, сурталчилгаа явуулж тодорхой шалгуурыг хангасан, үр дүнтэй ажил зохион байгуулсан тохиолдол тухайн жилийн төлөх татвараас хөнгөлөлт үзүүлж урамшуулах эрх зүйн орчинг бий болгох гэсэн заалтыг хасах.</p>
3.	Хууль зүй, дотоод хэргийн яам	<p>Төлөвлөгөөний төсөлд тусгагдсан ХЗДХЯ-ны хариуцан хэрэгжүүлэх арга хэмжээтэй холбогдуулан дараахь саналыг хүргүүлж байна:</p> <ol style="list-style-type: none"> 1. Төслийн 4.1.1.8-д заасан 1, 2 дугаар арга хэмжээг хэрэгжүүлэн 2019-2020 онд хүрэх түвшинг “хууль тогтоомжийн төсөл батлуулж, мөрдүүлэх” гэж заасныг өөрчлөх. Хууль тогтоомж батлах эрх хэмжээ нь зөвхөн УИХ-д хадгалагдах тул ХЗДХЯ-д үүрэг болгон болгон төлөвлөснийг хуулийн төслийг боловсруулан, УИХ-д өргөн мэдүүлэх гэсэн агуулгаар өөрчлөх; 2. Төслийн 4.1.5.5, 4.1.5.10, 4.1.5.11-д заасан арга хэмжээг хэрэгжүүлэгч “Хууль сахиулах байгууллага” гэдэгт ямар байгууллагуудыг багтаан ойлгох нь тодорхойгүй байх тул тодорхой нэрлэн заах; 3. Төслийн 4.1.5.15-ын 1-д заасан асуудал ХЗДХЯ-ны чиг үүрэгт хамаарахгүй тул хасах. Учир нь төслийн 4.1.5.15-д заасан 1 дүгээр арга хэмжээ судалгаа хийх, сурталчилах гэж ойлгогдохоор байна. Хэрэв сургалт, суртчилгаа, судалгааны ажил бол энэ нь ХЗДХЯ-ны дагнан хэрэгжүүлэх чиг үүрэг биш, харин АТГ-т хамаарахаар байна. Мөн 2 дугаар арга хэмжээ буюу “Аливаа хууль бус нөлөөлөл, түүний хэлбэрүүдийг

тодорхойлж, түүнд хүлээлгэх хариуцлагын тогтолцоог боловсронгуй болгох” үйл ажиллагааны хувьд Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах хэлбэрээр зохицуулахаар байх тул ЗГХЭГ хариуцах нь зүйтэй хэмээн үзэж байна. Мөн 2016-2020 онд Монгол Улсын Хууль тогтоомжийг 2020 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэлд энэ чиглэлээр тусгай хуулийн төсөл боловсруулахаар тусгагдаагүйг анхаарна уу;

4. Төслийн 4.1.7.1-д заасан 1 дүгээр арга хэмжээ нь ХЗДХЯ-ны хариуцах чиг үүрэгт хамаарахгүй бөгөөд Хууль тогтоомжийн тухай хуульд зааснаар ЗГХЭГ нь Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх, УИХТГ нь УИХ-д өргөн мэдүүлэх хууль тогтоомжийн төслийн бүрдүүлбэрийн хяналтыг хэрэгжүүлэхдээ холбогдох байгууллагаас санал авсан болон олон нийтээр хэлэлцүүлсэн эсэхийг хянадаг. Энэхүү асуудлыг нэгэнт хуулиар зохицуулах асуудал байх тул төлөвлөгөөнөөс хасах;

5. Төслийн 4.1.7.6-д заасан 2 дугаар арга хэмжээний 2021-2022 онуудад хүрэх түвшинг “нэхэмжлэл гаргасан төрийн бус байгууллагыг урамшуулах” гэж тодорхойлсон нь оновчгүй байна. Тухайн төрийн бус байгууллагыг ХЗДХЯ урамшуулах мэт болсон, мөн нэхэмжлэх эрхийг ТББ-уудад нээх, энэхүү эрхээ хэрэгжүүлэх боломжийг хангах зорилго бүхий зохицуулалт байхаас бус эрхээ хэрэгжүүлсний төлөө урамшуулал олгох зохицуулалтыг хуульчлах нь зохисгүй байх тул “... тэднийг урамшуулах механизм бүрдүүлэх” гэснийг хасах, мөн хүрэх үр дүнгийн түвшинг заасан үзүүлэлтийг өөрчлөх;

6. Төслийн 4.1.7.6-д заасан 4 дүгээр арга хэмжээний тухайд хэвлэл, мэдээллийн эх сурвалжийн дагуу эрүүгийн хэрэг үүсгэн шалгах хууль зүйн үндэслэл байхгүй, харин сэтгүүлч мэдээлэл өгсөн тохиолдолд хамтран ажиллаж болно. Зөвхөн сэтгүүлчийн өгсөн мэдээллийг урамшуулалд хамруулах зохицуулалтыг хуульд тусгах боломжгүй тул өнөөгийн эрх зүйн зохицуулалтын хүрээнд буюу Эрүүгийн байцаан шийтгэх хууль (УИХ-д өргөн мэдүүлсэн тус хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд ч энэ зохицуулалт хэвээр хадгалагдаж байгаа), Гэмт хэрэгтэй тэмцэх тухай хуульд заасны дагуу гэмт хэргийн талаарх мэдээллийг төлбөртэй авах боломжтойг анхаарна уу. Иймд энэ арга хэмжээг тусгайлан төлөвлөх шаардлагагүй тул хасах;

7. Төслийн 4.1.7.2-д заасан арга хэмжээний 2-т тухайн чиглэлээр хэлэлцүүлэг, уулзалт зохион байгуулах хугацааг “2018 он” болгож өөрчлөлт оруулах;

8. Төслийн 4.1.8.1-д заасан “Сэтгүүлчийг хуульд нийцсэн мэргэжлийнх нь үйл ажиллагааны улмаас эрүүгийн хариуцлагад татахгүй байх, мөн эрхэлж буй ажилтай нь холбогдуулан аливаа хохирол учруулсан, учруулахаар заналхийлсэн, биед нь халдсан үйлдэлд ногдуулах хариуцлагыг хуульчлах” арга хэмжээг 2018 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. Эрүүгийн хуульд энэ чиглэлээр бие даасан гэмт хэргийг тусгах боломжгүй бөгөөд энэ төрлийн үйлдэл, эс үйлдэлд хариуцлага хүлээлгэх нийтлэг зохицуулалт байгаа тул төлөвлөгөөнөөс хасах;

9. Төслийн 4.1.8.2-т заасан 4 дэх арга хэмжээ нь ХЗДХЯ-ны чиг үүрэгт хамаарахгүй тул хариуцах байгууллагыг нь өөрчлөн, ГХЯ болон тухайн асуудлыг хариуцсан яамдыг нэрлэн заах;

10. Төслийн 4.1.8.4-т заасан үйл ажиллагааны 2 дахь арга хэмжээ нь Сангийн яам чиг үүрэгт хамаарах тул тэргүүлэн хэрэгжүүлэгчийг Сангийн яам болгон өөрчлөх;

11. Төслийн 4.1.8.5-д -т заасан “Сэтгүүлчдийн мэргэжлийн ёс зүйн дүрэм, Хэвлэл мэдээллийн зөвлөлийн ажиллах журмыг боловсронгуй болгох” асуудал нь ХЗДХЯ-ны чиг үүрэгт хамаарахгүй тул хэрэгжүүлэгч байгууллагыг өөрчлөх;

12. Төслийн 4.1.11.1-ийн 1 болон 4.1.11.4-ийн 1-д заасан 2017-2020 онуудад хүрэх түвшингийн томъёоллыг өөрчлөх, мөн төслийн 4.1.11.1-ийн 2-т тодорхой улсуудын нэрийг заах шаардлагагүй юм. Учир нь одоо үйлчилж буй 20 улстай байгуулсан 28 төрлийн “Эрх зүйн харилцан туслалцааны гэрээ”-г Авлигын эсрэг НҮБ-ын конвенцийг эрх зүйн харилцан туслалцааны үндэслэл болгох зорилгоор шинэчлэхэд хүндрэлтэй тул уг асуудлыг судалж үзэх, харин цаашид шинээр байгуулах Эрх зүйн харилцан туслалцааны гэрээнд Авлигын эсрэг НҮБ-ын конвенцийг эрх зүйн харилцан туслалцааны үндэслэл болгон хэрэглэх асуудлыг тусгах боломжтой юм. Мөн Монгол Улсын иргэд ихээр зорчдог, сурч ажилладаг улсуудтай Эрх зүйн

		харилцан туслалцааны гэрээ байгуулах асуудлыг шаардлагатай тохиолдолд ХЗДХЯ өөрийн бүрэн эрхийн хүрээнд тухайн орны холбогдох байгууллагуудтай хамтран шийдвэрлэж ирснийг анхаарна уу.
4.	Сангийн яам	<p>Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний төсөлтэй танилцаад дараахь саналын өөрчлөлтийг хүргүүлж байна:</p> <p>1.Төслийн 4.1.3.2-ын 2-т Төрийн санхүүгийн хяналт шалгалт болон төрийн аудит, дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтын чиг үүргийн давхардлыг арилгах гэж заасан байна. Тус асуудал нь 2014 оны 11 сард засгийн газрын тогтоолоор уг чиг үүргүүдийг салгасан болно. Тус заалтын оронд тухайн салбарын хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох, үйл ажиллагааг илүү төлөвшүүлэх үүднээс “Дотоод аудитын тогтолцоог боловсронгуй болгох, давхардлыг арилгах” гэсэн заалтыг оруулах;</p> <p>2.Төслийн 4.1.3.2-ын 3-т Аудитын болон санхүүгийн хяналт шалгалтын дүгнэлтийг үнэн зөв гаргаагүй албан тушаалтанд зөрчлийн болон эрүүгийн хуулийн дагуу хариуцлага хүлээлгэх эрх зүйн зохицуулалтыг бий болгох гэсэн байгаа, энэ заалтын хүрээнд нэмэлтээр, эс бөгөөс нэмэлт заалтаар Санхүү, төсвийн холбогдолтой хууль тогтоомж зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлага эрх зүйн зохицуулалтыг бий болгох гэсэн заалтыг оруулах; Учир нь Санхүү, төсвийн холбогдолтой хууль тогтоомж зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлага эрх зүйн зохицуулалт одоогоор гарч байгаа хууль тогтоомжинд ороогүй байна.</p> <p>3.Төслийн 4.1.3.3-ын 1-д Санхүүжилтийн эх үүсвэрийг үл харгалзан Засгийн газрын тусгай сангийн санхүүжилт, зарцуулалтын мэдээллийг олон нийтэд ил тод мэдээлэх, “Шилэн данс”-ны сайтад байршуулах арга хэмжээ авах гэснийг “Засгийн газрын тусгай сангийн санхүүжилт, зарцуулалтын мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд “ЗГ-ын тусгай сангийн мэдээлэл” гэсэн цэсээр олон нийтэд мэдээлэх ажлыг зохион байгуулах” гэж өөрчлөн найруулж, хамтрагч байууллагууд дээр холбогдох яамд гэж оруулах;</p> <p>4.Төсвийн 4.1.3.3-ын 3-т Засгийн газрын сан хөрөнгө бэлтгэдэггүй шууд зарцуулалт хийгддэг учраас хөрөнгийн ашиглалт гэсэн асуудал гарахгүй тул Засгийн газрын тусгай сангийн хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, үр ашигтай байдлыг сайжруулах, үр дүнг олон нийтэд мэдээлэх гэсэн заалтыг хасах саналтай байна.</p> <p>5.Төслийн 4.1.3.6-ын 1-т Төсвийн ерөнхий захирагчийн санхүүгийн дотоод аудитын хяналтын хараат бус байдлыг хангаж, хариуцлагын тогтолцоог боловсронгуй болгох гэсэн заалтын “2017-2018 он” гэснийг “2017-2019” гэж сунгах;</p> <p>6.Төслийн 4.1.3.6-ын 2-т Төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд хийх хөндлөнгийн хяналт шалгалтын одоогийн тогтолцоонд шинжилгээ хийх, эрх зүйн орчинг судлах, холбогдох арга хэмжээг авах гэж заасан асуудал манай яамны чиг үүрэгт хамаарахгүй тул үндсэн хэрэгжүүлэгч байгууллагаар ҮАГ гэж өөрчлөх;</p> <p>7. Төслийн 4.1.3.6-ын 3-т “аудиторын мэргэжлийн ёс зүйн хариуцлагыг дээшлүүлэх” гэж заасан байна. Тухай заалтын хэрэгжилтийг тайлагнах, үнэлэх хүндрэлтэй тус шалгуур үзүүлэлтийг тодорхой болгох шаардлагатай;</p> <p>8. Төслийн 4.1.3.8-ын 1-д “Аудитын байгууллага үйл ажиллагаагаа хуулийн дагуу гүйцэтгэх боломж бүрдүүлэх” гэсэн байна. Энэ хэсгийн зорилт болон үр дүнгийн түвшин гэсэн хоёр үзүүлэлтүүд агуулгын хувьд солигдсон байсан тул “Аудитын байгууллагын ажиллах тэгш нөхцөлийг хангах” гэж өөрчлөх;</p> <p>9. Төслийн 4.1.3.8-ын 2-т “Аудитын байгууллагад тусгай зөвшөөрөл олгох, сунгах нөхцөл, үндэслэлийг боловсронгуй болгох, тусгай зөвшөөрөл бүхий аудитын байгууллагаас хийсэн Аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийг олон нийтэд нээлттэй болгоход чиглэсэн арга хэмжээ авах” гэснийг “Тусгай зөвшөөрөл бүхий аудитын байгууллагаас хийсэн аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмж болон тусгай зөвшөөрөл бүхий аудитын байгууллагад Төрийн захиргааны байгууллагаас хийсэн хяналт шалгалтын дүнг олон нийтэд нээлттэй болгоход чиглэсэн арга хэмжээ авах” гэж тус тус өөрчлөх саналтай байна.</p> <p>Мөн энэ хэсгийн “Аудитын байгууллагад тусгай зөвшөөрөл олгох, сунгах нөхцөл үндэслэлийг боловсронгуй болгох” гэснийг хасахаар тусгах саналтай байна. Учир нь Аудитын тухай хууль 2016 оны 1 дүгээр сарын 1-ны өдрөөс эхлэн шинэчлэгдсэнээр уг хуульд тусгай зөвшөөрөл олгох, сунгах асуудал шинэчлэгдэн тусгагдсан</p>

		байгаа. /Жич: Жилд дунджаар 10-15 байгууллага тусгай зөвшөөрөл шинээр авах буюу сунгах хүсэлт ирүүлдэг байгаа иймд цахимаар олгох буюу сунгах асуудал үр ашиг муутай гэж үзэж байна.
5.	Гадаад харилцааны яам	“Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-ний төсөл болон Засгийн газрын тогтоолын төслийг дэмжиж байна.
6.	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам	Тусгайлан өгөх саналгүй. Зарчмын хувьд дэмжиж байна. Төлөвлөгөөний төсөлд зарим арга хэмжээг хэрэгжүүлэх байгууллага нь тодорхойгүй байгааг анхаарна уу.
7.	Батлан хамгаалахын яам	Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний төсөл болон Засгийн газрын тогтоолын төсөлтэй танилцаад дэмжиж байна.
8.	Зам, тээврийн хөгжлийн яам	Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний төсөл болон Засгийн газрын тогтоолын төслийг дэмжиж байна. Харин Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр батлах тухай 51 дүгээр тогтоолын 2-т “... холбогдон гарах зардлыг жил бүрийн улсын төсөвт тусгаж байхыг Монгол Улсын Засгийн газарт даалгасугай” гэж заасан байх тул Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний төсөлд үйл ажиллагааг хэрэгжүүлэх арга хэмжээнд шаардагдах хөрөнгийн эх үүсвэр, хэмжээг тусгаж өгөх саналтай байна.
9.	Байгаль орчин, аялал жуулчлалын яам	Төслийг дэмжиж байгаа бөгөөд тусгайлан өгөх саналгүй болно.
10.	Эрчим хүчний яам	Засгийн газрын тогтоолын төслийг зарчмын хувьд дэмжиж байна. Тусгайлан өгөх саналгүй болно.
11.	Барилга, хот байгуулалтын яам	Тогтоолын төслийг дэмжиж байна.
12.	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам	Засгийн газрын тогтоолын төсөл өгөх зарчмын зөрүүтэй саналгүй байна.
13.	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамнаас өгсөн санал тусгагдсан байх тул тусгайлан өгөх саналгүй болно.
14.	Эрүүл мэндийн яам	Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний төсөл болон Засгийн газрын тогтоолын төслийг зарчмын хувьд дэмжиж байна.
15.	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам	Засгийн газрын тогтоолын төслийг дэмжиж, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний төсөлд дараах саналыг өгч байна. Үүнд: -4.1.1.8-н 1 дэх заалтын хэрэгжүүлэгч байгууллагын оролцогч гэсэн баганад “Бүх шатны төрийн байгууллага” гэж нэмэх; -4.1.1.10 дахь үйл ажиллагааг хэрэгжүүлэх арга хэмжээний 1-д “...институт” гэсний “...төв” гэж өөрчлөх; - 4.1.1.9-н 2; 4.1.2.1-н 2; 4.1.2.6-н 2 дахь заалтын үйл ажиллагааг хэрэгжүүлэх арга хэмжээнүүд агуулгын хувьд давхардсан байна. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтийг тайлагнах, хэрэгжүүлэх байгууллагыг нарийвчлан тодорхой болгож, боловсруулалтыг сайжруулан найруулгын шинжтэй засваруудыг төсөлд тусгах саналтай байна.
16.	Улсын дээд шүүх	Тусгайлан гаргах саналгүй болно.
17.	Улсын ерөнхий прокурорын газар	Тусгайлан гаргах саналгүй байна.
18.	Шүүхийн ерөнхий зөвлөл	Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний төслийн 4.1.5.2 дахь хэсгийн 2,3 дахь арга хэмжээг хасах саналтай байна. 1. Шүүхийн хараат бус байдлыг хангахуйц шүүхийн дэд бүтцийг бүрдүүлэх зорилгоор шүүхийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх,

		<p>2. Албан үүргээ гүйцэтгэж байгаа шүүгч, прокурорт төрийн одон медалиар шагнадаг тогтолцоог өөрчлөх,</p> <p>3. Шинээр томилогдсон шүүгчдэд зориулсан сургалтын тусгай хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх,</p> <p>4. Шүүгчийн сургалтын төвийн чадавх, сургалтын танхим, тоног төхөөрөмжийн хангамжийг сайжруулах,</p> <p>5. Шүүгчийн сүүлийн 3 жилийн үйл ажиллагаанд хийсэн тоон судалгаа, хөндлөнгийн шинжээчийн дүгнэлтэд тулгуурлан тухайн шүүгчийг сургалтад хамруулах зэрэг 5 ажлыг нэмж тусгуулах саналтай байна.</p>
19.	Төрийн албаны зөвлөл	<p>“Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө болон уг төлөвлөгөөг батлах Засгийн газрын тогтоолын төслүүдтэй танилцаад зарчмын хувьд дэмжиж дараахь саналыг хүргүүлж байгааг хүлээн авна уу.</p> <p>1. төслийн 4.1.1.2-н 1.5, 4.1.1.3-н 1, 4.1.1.7-н 1, 4.1.1.10-н 1 дэх хэсгүүдэд заасан “нийтийн” гэснийг “төрийн” гэж өөрчлөх</p> <p>2. төслийн 4.1.1.2-н 5 дахь хэсгийг “төрийн албан тушаалтны ажлын байрны тодорхойлолтод тавигдах нийтлэг шаардлагыг батлах, эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох” гэж өөрчлөх</p> <p>3. төслийн 4.1.1.6-н 1 дэх хэсгийг “төрийн албан хаагчдын ёс зүйн дүрмийг судлах, дүн шинжилгээ хийх, төрийн албаны ёс зүйн үлгэрчилсэн дүрмийг батлуулах мөн 2 дахь хэсгийг “үлгэрчилсэн дүрмийн хүрээнд төрийн албан хаагчдын ёс зүйн дүрмийг салбар бүрээр батлуулах” гэж тус тус өөрчлөн найруулах</p> <p>4. Төслийн 4.1.1.2, 4.1.1.3, 4.1.1.7, 4.1.1.10-т тусгагдсан арга хэмжээг хэмжээнүүдийг хэрэгжүүлэх байгууллагууд нь төрийн байгууллагууд байх тул “төрийн” гэсэн нэр томъёог хэрэглэх нь зүйтэй гэж үзсэнийг уламжилъя.</p>
20.	Үндэсний Аудитын газар	<p>“Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-д Үндэсний аудитын газар нь 36 арга хэмжээг үндсэн болон хамтрагч оролцогчоор хэрэгжүүлэхээр туссан байгаатай танилцаад дараахь саналыг хүргүүлж байна. Үүнд:</p> <p>1. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрт тусгагдсан 4.1.2.4-ийн 1, 2 дахь арга хэмжээнээс ҮАГ-ыг хасах саналтай байна. Аж ахуйн нэгжийн дотоод хяналтыг бэхжүүлэх, эрсдэлд суурилсан хяналт шалгалт хэрэгжүүлэх талаар хууль тогтоомжийг боловсронгуй болгох, аж ахуйн нэгжийн дотоод хяналтын стандартыг боловсронгуй болгох зэрэг дотоод хяналтын үйл ажиллагаа нь төрийн аудитын байгууллагын чиг үүрэгт хамааралгүй байна. ҮАГ нь Төсвийн тухай хуульд заасны дагуу санхүүгийн аудитыг, Төрийн аудитын тухай хуулийн 16.2-т заасны дагуу УИХ-ын Төсвийн Байнгын Хороогоор иргэд олон нийтийн анхааралд буй үнэн зөв хариу хүссэн аудитын сэдвийг батлуулан төрийн байгууллагуудад аудитыг хийж байна. Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар нь төрийн өмчит аж ахуйн нэгжийн дотоод хяналтын үйл ажиллагааг бэхжүүлэх чиг үүргийг хэрэгжүүлдэг тул тус газрыг хамтран хэрэгжүүлэгч байгууллагаар нэмэх саналтай байна.</p> <p>2. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрт тусгагдсан 4.1.3.1-ийн 6, 4.1.3.2-ын 1, 4.1.3.3-ын 2, 3 дахь арга хэмжээнээс ҮАГ-ыг хасах саналтай байна. Хувь хүн, хуулийн этгээдээс төсвийн байгууллагад өгсөн хандив, тусламж гэх мэт төсвийн бус орлого, түүний зарцуулалтыг мэдээлэх, Засгийн газрын тусгай сангийн хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, үр ашигтай байдлыг сайжруулах, үр дүнг олон нийтэд мэдээлэх ажлыг хэрэгжүүлэх нь Засгийн газрын үйл ажиллагаа юм.</p> <p>3. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрт тусгагдсан 4.1.3.2-ын 2 дахь арга хэмжээнээс төрийн аудит болон ҮАГ-ыг хасах саналтай байна. Төрийн аудитын байгууллага аудитын дүнг иргэд олон нийт, УИХ-д нээлттэй, ил тод хүргүүлдэг бол дотоод аудит зөвхөн гүйцэтгэх засаглал болон тухайн байгууллагын удирдлагад мэдээлэх чиг үүргийг хүлээдэг. Олон улсын жишиг мөн ийм чиглэлээр хэрэгжиж байна.</p> <p>4. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрт тусгагдсан 4.1.3.2-ын 3, 4.1.9.1-ийн 1-3, 4.1.9.2-ын 1-3, 4.1.9.3-ын 1-3 дахь арга хэмжээнүүдээс ҮАГ-ыг хасах саналтай байна. ҮАГ-ын бүрэн эрх, чиг үүрэгт хамааралгүй асуудлаар Хууль тогтоомжийн тухай хуулийн 2.1.1-д заасны дагуу хууль санаачлах эрх ҮАГ-т байхгүй байна.</p> <p>5. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрт тусгагдсан 4.1.3.3-ын 2 дахь тусгай сангийн хөрөнгийг захиран зарцуулах шийдвэрийн ил тод нээлттэй байдлыг хангах, иргэд олон нийтийн зүгээс хяналт тавих боломжийг олгох тухай арга хэмжээнээс ҮАГ-ыг хасах саналтай байна. Засгийн газрын 28 тусгай санг захиран</p>

		<p>зарцуулах, шийдвэр гаргах, мэдээлэл байршуулах эрх нь тухайн төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхийн хүрээнд байхаар тус тусын хуулиар зохицуулагдсан.</p> <p>6. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрт тусгагдсан 4.1.3.6-ын 1, 3, 4.1.3.7-ын 3, 4.1.3.8-ын 1, 2 дахь арга хэмжээнээс ҮАГ-ыг хасах саналтай байна. Төсвийн ерөнхий захирагчийн санхүүгийн дотоод аудитын тогтолцоог боловсронгуй болгох нь хууль, дотоод аудитын дүрмийн дагуу Сангийн яам, төсвийн ерөнхийлөн захирагч нар өөрсдөө байхаар заасан.</p> <p>7. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрт тусгагдсан 4.1.3.7-ын 2 дахь арга хэмжээнд ҮАГ-ыг үндсэн хэрэгжүүлэгч гэснийг хамтрагч байгууллага болгох саналтай байна. Захиргааны ерөнхий хуулийн 103.2-т "Энэ хуулийн 103.1-д заасан гэм буруутай албан тушаалтнаар хохирлыг төлүүлэх үүргийг тухайн захиргааны байгууллагын дээд шатны байгууллагын дотоод аудитын нэгж хариуцна." гэж заасан тул үндсэн хэрэгжүүлэгчээр ЗГХЭГ, СЯ, ТЕЗ нар байна.</p> <p>8. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрт тусгагдсан 4.1.3.9-ийн 1 дэх заалт нь 2 дахь арга хэмжээнээс хамаарч хэрэгжихээр байгаа тул нэгтгэх саналтай байна. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрт тусгагдсан 4.1.3.9-ийн 3 дахь заалтын хэрэгжих хугацааг 2018 оноос эхлүүлэх саналтай байна.</p> <p>9. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрт тусгагдсан 4.1.3.10-ын 4 дэх заалтыг дахин найруулах саналтай байна.</p> <p>10. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрт тусгагдсан 4.1.7.3-ын 1 дэх заалтыг хасах саналтай байна. Төрийн аудитын тухай хуулийн 7.2-т "Үндэсний аудитын газар нь Монгол Улсын аудитын дээд байгууллага бөгөөд Монгол Улсын хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрт захирагдана. Үндэсний аудитын газар болон Монгол Улсын Ерөнхий аудиторын үйл ажиллагаанд Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн дарга, Улсын Их Хурлаас бусад байгууллага, албан тушаалтан хяналт тавих, үүрэг даалгавар өгөхийг хориглоно." гэж заасан байна.</p> <p>11. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрт тусгагдсан 4.1.3.1-ийн 3-5 дахь заалт, 4.1.3.10-ын 1-3 дахь заалтуудад тусгагдсан арга хэмжээнүүдийг дэмжиж байгаа болно.</p>
21.	Монголбанк	"Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр"-ийн дагуу хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө болон түүнийг батлах Засгийн газрын тогтоолын төсөлтэй танилцаад төслийг дэмжиж байна.
22.	Санхүүгийн зохицуулах хороо	Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний төсөл болон Засгийн газрын тогтоолын төслийг зарчмын хувьд дэмжиж, тусгайлан өгөх саналгүй болно.
23.	Сонгуулын ерөнхий хороо	<p>Хууль тогтоомжийг боловсронгуй болгох үйл ажиллагааны чиглэлээр Сонгуулийн Ерөнхий Хороо нь Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.10-д зааснаар сонгуулийн тухай хууль, тогтоомжийг боловсронгуй болгох талаар Улсын Их Хуралд санал тавих эрхтэй гэж заасан. Гэтэл Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний төсөл дээр дурьдсаны дагуу тус Хорооноос хүргүүлсэн саналаас гадна Улс төрийн намын санхүүжилт, түүнийг олон нийтэд ил тод нээлттэй болгох, Хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийн байгууллагыг улс төр, бизнесийн бүлэглэлийн хууль бус ашиг сонирхол, нөлөөллөөс ангид байлгах чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх үндсэн байгууллага байхаар төлөвлөсөн байна.</p> <p>Монгол Улсын Их Хурлын 2016 оны 51 дүгээр тогтоолоор батлагдсан "Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр"-ийн 2.1.9-д "улс төрийн намын болон сонгуулийн санхүүжилтийг олон нийтэд ил тод, нээлттэй болгох, хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийн байгууллагыг улс төр, бизнесийн бүлэглэлийн хууль бус ашиг сонирхол, нөлөөллөөс ангид байлгах;" гэж тусгасан энэхүү зорилтын хүрээнд Сонгуулийн ерөнхий Хороо нь зөвхөн хуулиар олгогдсон бүрэн эрхийнхээ дагуу "Улс төрийн намын сонгуулийн санхүүжилтийг ил тод, нээлттэй болгох" чиглэлээр тодорхой арга хэмжээг авч хэрэгжүүлэх боломжтой юм.</p> <p>Тухайлбал: Хөтөлбөрийн 4.1.9.1-д заасан үйл ажиллагааны чиглэлээр "... сонгуулийн санхүүгийн тайлан гаргах, түүнд хийсэн аудитын дүгнэлтийг мэдээлэх зэрэг үүргээ биелүүлээгүй тохиолдолд хүлээлгэх хариуцлагыг нарийвчлан зохицуулах замаар улс төрийн намын санхүүжилтийн үйл ажиллагаанд тавих</p>

		<p>хяналтын тогтолцоог сайжруулах, хууль байгаа зохицуулалтыг үр нөлөөтэй хэрэгжүүлэх;”, 4.1.9.4-д “Сонгуулийн тухай хууль, Улс төрийн намын тухай хуулитгй боловсронгуй болгох;” чиглэлээр төлөвлөсөн Улс төрийн намын сонгуулийн санхүүжилт түүний ил тод, нээлттэй байдал, мөн сонгуулийн тухай хууль тогтоомжийг боловсронгуй болгох чиглэлээрх арга хэмжээг хэрэгжүүлэх боломжтой.</p> <p>Харин улс төрийн намын санхүүжилт түүний ил тод байдал, хууль тогтоох, гүйцэтгэх шүүх эрх мэдлийн байгууллагыг улс төр, бизнесийн бүлэглэлийн хууль бус ашиг сонирхол, нөлөөллөөс ангид байлгах зэрэг чиглэлээр төсөлд тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлэх, хууль зүйн боломжгүй юм.</p> <p>Иймд хөтөлбөрийн 4.1.9.2-д заасныг хэрэгжүүлэх 3 үйл ажиллагаа, 4.1.9.3-д заасныг хэрэгжүүлэх 3 үйл ажиллагаа, 4.1.9.4-д заасныг хэрэгжүүлэх 8 үйл ажиллагааны 5,6 дахь үйл ажиллагаа, 4.1.9.5-д заасныг хэрэгжүүлэх 3 үйл ажиллагаа, 4.1.9.6-д заасныг хэрэгжүүлэх 1 үйл ажиллагаа, 4.1.9.7-д заасныг хэрэгжүүлэх 4 үйл ажиллагаа, 4.1.9.8-д заасныг хэрэгжүүлэх 3 үйл ажиллагаа зэргийг хуулиар эрх нь олгогдсон төрийн холбогдох бусад байгууллага хэрэгжүүлэхээр төсөлд тусгуулах нь зүйтэй гэж үзэж байна.</p> <p>Мөн хөтөлбөрийн 4.1.9.4-д заасныг хэрэгжүүлэх 8 үйл ажиллагааны 2 дугаарт заасан арга хэмжээнээс “Улс төрийн намууд жил бүр санхүүгийн тайлан гаргаж, интернетэд байршуулах...” гэснийг 4.1.9.2-д заасан арга хэмжээнд нэгтгэх зэрэг саналтай байгааг үүгээр хүргүүлж байна.</p>
24.	Үндэсний статистикийн хороо	Саналгүй.
25.	Хүний эрхийн үндэсний комисс	Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний 2017-2023 оны төлөвлөгөөний төсөлтэй танилцлаа. Төлөвлөлөөнд тусгуулах нэмэлт саналгүй болно.
26.	Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газар	“Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-ний төсөлтэй танилцлаа. Төсөлд тусгайлан өгөх саналгүй, зарчмын хувьд дэмжиж байна.
27.	Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар	Тус арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулах явцад өгсөн санал тусгагдсан байгаа тул өөр саналгүй болно. Арга хэмжээний төлөвлөгөөний 4.1.3.4-н нэгд заасан арга хэмжээг хамтран хэрэгжүүлэх байгууллага баганд МТШХХГ гэснийг ХХМТГ гэж өөрчлөх.
28.	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар	<p>Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний төсөлд дараахь саналыг өгч байна. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. төслийн 4.1.4.1 дэх үйл ажиллагааны 2 дахь заалтын “дуудлага худалдаа, барьцааг” гэснийг хасч, “...шалгаруулалтыг цахим хэлбэрээр зохион байгуулах” гэж найруулах; 2. төслийн 4.1.4.2 дахь үйл ажиллагааны 1 дэх заалтын “... журмыг шинэчлэн боловсруулах...” гэсний “шинэчлэн” гэдэг үгийг хасч, найруулан боловсруулах, мөн түүнтэй уялдуулан шалгуур үзүүлэлтийг найруулах; 3. төслийн 4.1.4.2 дахь үйл ажиллагааны 1 дэх заалтын үндсэн хэрэгжүүлэгчээс ТӨБЗГ-ыг хасч, хамтран хэрэгжүүлэгч байгууллагаар оролцуулах. <p>Худалдан авах ажиллагааны мэргэжлийн байгууллагын албан хаагчдын сарын дундаж цалин 600.0-650.0 мянган төгрөг, цалингийн шатлал доогуур, орон нутгийн нэгжийн орон тоо цөөн, нэг албан хаагч олон тооны тендер шалгаруулалтыг зохион байгуулдаг зэргээс шалтгаалан авлигад өртөх эрсдэл байдаг. Тиймээс худалдан авах ажиллагааны салбарын албан хаагчдын цалин, нийгмийн баталгааг нэмэгдүүлэх эрх зүйн орчин бүрдүүлэх талаар Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тодорхой асуудал тусгахыг танаас хүсье.</p>

29.	Үндэсний хөгжлийн газар	<p>“Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-нд дараахь саналыг хүргүүлж байна.</p> <p>1. “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-ний 4.1.4.4 дэх хэсгийн 1 дэх хэсгийг хасуулах саналтай байна. Учир нь концесс, шууд гэрээ байгуулах аргачлал, шалгуурыг тодорхой болгох хэсэгт Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагаанд мөрдөх журмыг сонгоход баримтлах босго үнэ түүнд тавих шалгуурыг шинэчлэн батлах асуудал хамаарахгүй болно.</p> <p>2. Тус төлөвлөгөөний 4.1.4.4 дэх хэсгийн 3 дахь хэсгийн “Төрийн болон хувийн түншлэлийг эргэж харах, концесс шалгаруулалтын үйл явцыг шудрага, өрсөлдөөнтэй, үр дүнтэй, ил тод болгох” гэснийг “Концесс олгох уралдаант шалгаруулалт болон санал үнэлэх журмыг шударга, өрсөлдөөнтэй, үр дүнтэй, ил тод болгох талаар шинэчлэн боловсруулах.” гэж өөрчлөх</p> <p>3. 4.1.4.4-ийн 2 болон 3 дахь хэсгийн хэрэгжүүлэх байгууллагын үндсэн гэсэн дээр ҮХГ, хамтрагч дээр нь ЗГХЭГ гэж өөрчлөх, ТӨБЗГ гэснийг хасах саналтай байна.</p>
30.	Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газар	<p>1. Төлөвлөгөөний төслийн 4.1.1.5-ын 2-д 2018 онд “аргачлалын дагуу үнэлгээ хийх” гэж нэмэх, эсхүл 2017 оны хүрэх үр дүнг хасах, төсвийг 10.0 төгрөгөөр төсөвлөж оролцогчийг “холбогдох байгууллага” гэж өөрчлөх;</p> <p>2. Төслийн 4.1.2.1-ийн 3-т Төрийн үйлчилгээний салбарт “цахим боловсрол”, “цахим эрүүл мэнд”, “цахим нэг иргэн-нэг бүртгэл” төслийг хэрэгжүүлэх хэрэгжүүлэх байгууллагуудыг тогтоох;</p> <p>3. Төслийн 4.1.2.7-ын 1-т хийж гүйцэтгэх арга хэмжээг 2017 онд хэрэгжүүлэхэд 15.0 сая төгрөгийг төсөвлөх;</p> <p>4. Төслийн 4.1.3.8-н 1-г “Аудитын байгууллага, дотоод аудитын нэгжийн үйл ажиллагааг хуулийн дагуу гүйцэтгэх боломжийг бүрдүүлэх” гэж өөрчлөх, 2-г “Аудитын байгууллага, дотоод аудитын нэгжийн тусгай зөвшөөрөл олгох, сунгах нөхцөл, үндэслэлийг боловсронгуй болгох, тусгай зөвшөөрөл бүхий аудитын байгууллагаас хийсэн Аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийг олон нийтэд нээлттэй болгоход чиглэсэн арга хэмжээ авах” гэж өөрчлөх;</p> <p>5. төслийн 4.1.7.2-н 3-г хамтран хэрэгжүүлэх байгууллагаас ОӨУБЕГ-ыг хасах зэрэг саналтай байна.</p>
31.	Ашигт малтмал, газрын тосны газар	Төлөвлөгөөний төсөлд “Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлыг дэмжих” чиглэлээр авч хэрэгжүүлэхээр тусгасан арга хэмжээнд нэмж оруулах тусгайлсан санал байхгүй байна.
32.	Монголын олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын ажлын алба	Монгол Улсын Их Хурал 2016 оны 11 дүгээр сарын 03-ны өдрийн 51 дүгээр тогтоолоороо Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг баталж, түүний дагуу ирүүлсэн Засгийн газрын тогтоол, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний төслүүдтэй танилцаж, бүрнээ дэмжиж байгаагаа илэрхийлье.
33.	Монголын сэтгүүлчдийн нэгдсэн эвлэл	<p>Төсөлд дараахи 2 саналыг тусгуулах саналтай байна. Үүнд:</p> <p>1. АТҮХ-ийн зорилт 8-ын 1-1 буюу Төрөөс хэвлэл мэдээллийн талаар баримтлах бодлого боловсруулж батлуулахад МСНЭ тэргүүтэй хэвлэл мэдээллийн мэргэжлийн ТББ-уудаас санал авах механизм бий болгох, Оролцогчоор оролцуулах;</p> <p>2. Зорилт 8-ын 5-1-д Сэтгүүлчийн мэргэжлийн ёс зүйн дүрмийг боловсруулах, батлах, хяналт тавих асуудлыг ХЗДХЯ хэрэгжүүлэхээр тусгасан нь хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалт /self regulation/-ын зарчмыг зөрчиж байгаа тул Үндсэн хэрэгжүүлэгчээр Хэвлэл мэдээллийн зөвлөл, хамтрагч, оролцогчоор хэвлэл мэдээллийн мэргэжлийн байгууллагууд, төрийн холбогдох байгууллага байхаар тусгах.</p>
34.	Хэвлэл мэдээллийн зөвлөл	1. Төслийн 4.1.8.1.2, 4.1.8.1.3, 4.1.8.2.2, 4.1.8.2.2, 4.1.8.2.3, 4.1.8.2.4, 4.1.8.3.1, 4.1.8.5.1, 4.1.8.5.2 заалтуудад тусгагдсан асуудлаар хамтран ажиллах боломжтой гэж үзэж байна.

		<p>2. Төслийн 4.1.8.5.1 заалтад “Сэтгүүлчийн мэргэжлийн ёс зүйн дүрэм, Хэвлэл мэдээллийн зөвлөлийн ажиллах журмыг боловсронгуй болгох, хариуцлагыг нэмэгдүүлэх” гэснийг “Сэтгүүлчийн мэргэжлийн ёс зүйн дүрмийг редакци, сэтгүүлчдэд мөрдүүлэх, таниулан сургах, хэвлэл мэдээллийн зөвлөлийн үйл ажиллагааг олон нийтэд таниулан мэдүүлэх ажлыг төр, хэвлэл мэдээллийн зөвлөл хамтран зохион байгуулах” ба “Хэвлэл мэдээллийн байгууллагын хариуцлагыг тодорхой болгож, ёс зүйн алдаа гаргасан хэвлэл мэдээллийн байгууллага уучлал хүсэх, залруулга гаргах үүрэг хүлээх тухай эрх зүйн зохицуулалт бий болгох” гэсэн 2 заалт болгон өөрчлөх саналтай байна.</p> <p>3. Хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүлчдийг шүүхэд нэхэмжлэл гаргахтай холбоотой асуудлаар шүүх, хууль хяналтын байгууллагуудтай хамтран ажиллах боломж нөхцөлийг бий болгох” гэсэн заалт шинээр нэмэх саналтай байна.</p>
35.	Глоб интернэшнл төв	<p>Төлөвлөгөөний 8 дахь зорилтын хүрээнд дараах саналыг хүргүүлж байна.</p> <p>1. Сэтгүүлчдийн аюулгүй байдлын талаар судалгаа, хяналт мониторинг хийх.</p> <p>2. Хууль сахиулах байгууллагын ажилтан, албан хаагчдад эрэн сурвалжлах сэтгүүл зүй, сэтгүүлчдийн аюулгүй байдлыг хангах талаар сургалт хийх, тэдний мэдлэг ойлголтыг дээшлүүлэх.</p>
36.	Нээлттэй нийгэм форум	<p>4.1.3.1-д</p> <ul style="list-style-type: none"> - Нэгдсэн төсвийн Хагас жилийн тойм боловсруулж, нийтэд ил тод болгох (СЯ) - Нэгдсэн төсвийн Жилийн эцсийн тайланд төлөвлөгөө болон гүйцэтгэлийн талаар илүү дэлгэрэнгүй мэдээлэх (СЯ) - Нэгдсэн төсвийн төслийн тооцооллын хавсралт мэдээллийг эксель форматаар ил тод болгох талаар “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам”-д тусгах (СЯ) <p>4.1.3.2-д</p> <ul style="list-style-type: none"> - Төсвийн хяналтын сонсголын журмыг баталж, хэрэгжүүлэх (СЯ) <p>4.1.5.1-н</p> <p>1-3-д 2016 онд Оюуны Инноваци ТББ-аас “Шүүхийн хараат бус байдлын баталгаа: Шүүгчийн томилгоо” бодлогын үнэлгээг ННФ-бын дэмжлэгтэйгээр хийж гүйцэтгэсэн ба холбогдох бодлогын зөвлөмжийг ШЕЗ-д болон шүүгчдэд хүргүүлсэн болно. Үүнд шүүгчийн сонгон шалгаруулалт, томилгоог сайжруулах хууль болон журманд орох нэмэлт өөрчлөлтийн саналуудыг тусгасан. Дэлгэрэнгүй мэдээллийг доор холбоосоор орж авна уу: http://forum.mn/index.php?sel=project&menu_id=399</p> <p>2-д "шүүгчийн хараат бус байдал, хариуцлагыг дээшлүүлэх цогц арга хэмжээ хэрэгжүүлэх" гэсэн хүрээнд хийх ажил тодорхойгүй</p> <p>3-д Шүүгчид нэр дэвшигчдийн асуудлаар УЕПГ ямар ажил хийх вэ? Хэр хамааралтай талаар тодруулна уу. УЕПГ-т хамааралгүй</p> <p>4-д 2017 онд Нөлөөллийн мэдүүлгийн талаар бодлогын дүн шинжилгээ хийлгэхээр уралдаант шалгаруулалт зарлаад байна УЕПГ-т хамааралгүй</p> <p>5-д Шүүгчийн Ёс зүйн хорооны үйл ажиллагаатай холбоотой бодлогын дүн шинжилгээг Сайн туршлага ТББ ННФ-ын дэмжлэгтэйгээр хийсэн ба тайлан эцэслэгдэх шатандаа явж байна. Шүүгчийн ёс зүйн хорооны дүрмийг шинэчлэхтэй холбоотой шинжээчдийн уулзалт зохион байгуулах, Ёс зүйн хорооны шийдвэрүүдэд анализ хийх, нийтлэх ажлуудыг 2017 онд төлөвлөсөн.</p> <p>6-д Шүүх хуралдааныг ажиглалт хийдэг олон улсын туршлагаас харахад шүүх хуралдааныг хэсэгчлэн нээлттэй явуулах нь шүүхийн үйл ажиллагаанд бүрэн үнэлгээ дүгнэлт өгөх боломжгүй болгодог бөгөөд хаалттай шүүх хуралдаан явуулах шалгуур, журмыг илүү тодорхой болгох замаар шаардлагагүй тохиодолд хуралдааныг хаалттай явуулах байдлыг халах, шүүх хуралдааныг олон нийтийн ТВ-ээр нэвтрүүлэхгүй</p>

байхад анхаарах нь зүйтэй бөгөөд хэрэг хянан шийдвэрлэх процессыг бүрэн гүйцэт байдлаар ажиглаагүй байж дүгнэлт хийх нь маш том эрсдэлтэй тул энэ чиглэлд нэмэлт судалгаа шинжилгээ хийх шаардлагатай. 7-д ННФ-аас 2015 онд Доктор О.Мөнхсайханы “Монгол Улс дахь шүүгчийн сонгон шалгаруулалт: шүүгчид нэр дэвшигчийг үнэлэх ажиллагааг сайжруулах ньп судалганы бүтээлийг дэмжин хэвлэсэн. Энэхүү судалгааны бүтээлд анхаарах асуудал, зөвлөмжийг тусгасан ба салбарын хүрээнд танилцуулж хэлэлцүүлсэн протокол, видео бичлэг байгааг үүгээр мэдэгдэж байна.

4.1.5.2-н

1-д Ерөнхий шүүгчийн томилох асуудалд ХЗДХЯ ямар оролцоотой байхыг тодруулах

2-д ННФ-аас ШЕЗ-ийн гишүүдийн нэр дэвшүүлэх ажиллагааны талаар бодлогын зөвлөмж боловсруулаад байна.

4.1.5.5-н

2-д Мэдээллээ авч эхлээгүй байж хариуцлага хүлээлгэх тухай ярих нь оновчгүй. Ер нь энэ хүрээнд эрх зүйн зохицуулалт байгаа. Тиймээс "хариуцлага тооцох эрх зүйн орчинг бүрдүүлэх" гэснийг хасах.

4.1.5.6

Шүгэлдэгчийг (шүгэл үлээгч) хамгаалах тухай тусгайлсан эрх зүйн зохицуулалт бий болгох асуудлыг Хүний эрхийг хамгаалагчдын зохицуулалтаас тусад нь авч үзэх.

4.1.5.11-н

1-д "Тодорхой шалгуур" хангасан алба хаагчийн гүйцэтгэх үүрэг тодорхойгүй байна. Тиймээс ямар чиг үүрэг гүйцэтгүүлэхээр сонгож байгааг тодорхой болгох.

4.1.5.14

4-д Ойлгомжгүй үйл ажиллагаа тул тодруулах.

4.1.5.15

2-д 4.1.5.1.4-тэй уялдах эсэх

4.1.5.16

1-д Хууль тогтоомжийн тухай хууль, Захиргааны ерөнхий хуулийн дагуу хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний актын төслийг боловсруулах үе шатанд хийх үнэлгээ, судалгааны явцад энэ асуудлыг бүрэн дүүрэн шалгахаар байгаа тул харин хуулиар тогтоосон аргачлалыг бүрэн дүүрэн хэрэгжүүлэх хүрээнд төрийн алба хаагчдыг сургах, чадавхжуулах ажлыг төлөвлөх нь үр дүнтэй.

2-д АТГ энэ ажлыг хэрэгжүүлэхүйц хүний нөөц, чадавхийг бий болгох нь өндөр зардалтай тул, холбогдох хуулийн дагуу дүн шинжилгээ, үнэлгээ, судалгааг хийх чадавхийг бий болгох сургалт зохион байгуулах, хэрэгжүүлэх үе шатанд дүн шинжилгээ, мониторинг, хяналт тавих талаар үйл ажиллагааг тусгаж болох юм. Зарим асуудлаар АТГ-т төрийн байгууллага хүсэлт тавьж санал, дүгнэлт гаргуулах боломжтой байж болох юм.

4.1.5.17

1-д Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгад орсон заалтыг төгөлдөржүүлэх тухай тусгах.

4.1.6.5

1-д Эрдэс баялгийн салбарт гэрээний ил тод байдлыг хангах эрх зүйн орчныг бүрдүүлэх асуудлыг бие даасан үйл ажиллагаа болгож тусгах

Учир нь 2014 оноос эрдэс баялгийн салбарт гэрээний ил тод байдлыг хангах санаачилга өрнөж, эрх зүйн орчны дүн шинжилгээ хийж, гэрээний мэдээллийн нэгдсэн сан байгуулах ажил явагдаж байна. Гэсэн ч эрх зүйн орчин бүрдээгүйгээс гэрээнд нууцлалын заалт оруулах, байгууллагын нууцад хамааруулах замаар гэрээг нийтэд мэдээлэхээс татгалзах явдал түгээмэл байна. Иймд эрдэс баялгийн салбарт гэрээний ил тод байдлыг хангах асуудлыг гэрээ байгуулах үйл явцыг хамруулан цогц байдлаар зохицуулах эрх зүйн орчин шаардлагатай байна.

2-д Эрдэс баялгийн салбарт ашиг хүртэгч эздийн ил тод байдлыг хангах явдал нь холбогдох эрх зүйн орчныг бүрдүүлэхгүйгээр бүрэн хэрэгжих боломжгүй гэдэг нь ННФ-ын 2016 онд хийсэн судалгааны дүнгээс харагдаж байна. Иймд юуны өмнө ашиг хүртэгч эздийн тодорхойлолт, хамрах хүрээг оновчтой тодорхойлж, эрх зүйн орчныг бүрдүүлэх ажлыг 2017 онд хийж гүйцэтгэх. Үүний үндсэн дээр мэдээлэл цуглуулах баталгаажуулах, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлж олон нийтэд хүргэх ажлыг шат дараатай хэрэгжүүлэх нь зүйтэй.

3-д Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааг хялбаршуулах, иргэдэд ойлгомжтой нээлттэй болгох нь аргачлал боловсруулах төдийгөөр хэрэгжих ажил биш юм. Иймд тусгай зөвшөөрөл олгох үйл явцад орон нутгийн иргэдийн оролцоо, ил тод байдлыг хангах чиглэлээр Ашигт малтмалын тухай хууль тогтоомжийг сайжруулах. Ингэхдээ иргэдийн оролцоог Захиргааны ерөнхий хуульд нийцүүлэн журамлах.

4-д Газрын тосны хайгуул ашиглалтын үйл ажиллагаанд байгаль орчны хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах нь авлигын эрсдлийг бууруулахад төдийлөн ач холбогдолтой бус юм. Харин газрын тосны хайгуул ашиглалтын үйл ажиллагааны Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, байгаль орчны менежментийн төлөвлөгөө, тайланг батлах үйл явцад иргэдийн хяналт оролцоог хангах чиглэлээр хууль тогтоомжийг боловсронгуй болгож, хэрэгжилтийг хангах ажлыг төлөвлөгөөнд тусгах нь зүйтэй.

5-д Түгээмэл тархацтай ашигт малтмалын үйл ажиллагаа эрхлэгч аж ахуйн нэгжийг ОУИТБС-д хамруулах асуудлыг нэмж тусгах.

6-д Газрын тос, цацраг идэвхт ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагаанд ил тод, иргэдийн хяналт оролцоог хангах чиглэлээр эрх зүйн орчныг боловсронгуй болгох.

7-д ОУИТБС-ын тайлангаар илэрсэн тайлбарлаагүй зөрүүний мөрөөр арга хэмжээ авах. Авлига, ашиг сонирхлын зөрчил байгаа эсэхийг шалган тодруулах арга хэмжээ авах.

Төлөвлөгөөнд тусгасан зарим үйл ажиллагаа нь авлигыг бууруулах, түүнээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд олон нийт, иргэний нийгмийн хяналт оролцоог дээшлүүлэх Хөтөлбөрийн зорилготой нийцэхгүй байна. Харин ч эсрэгээсээ иргэний нийгмийн үйл ажиллагааг хумих, бүртгэл, хяналт тайлагналын шаардлагыг улам чангаруулахад чиглэсэн байгааг анхаарах хэрэгтэй байна. Тухайлбал, 4.1.7.2.3-д заасан иргэний нийгмийн ёс зүйн дүрмийг батлах, 4.1.7.2.4-д заасан төрийн бус байгууллагын үйл ажиллагаа, үүсгэн байгуулагч, хандив, орлогын мэдээллийг ил тод болгох, төрийн чиг үүргийг гэрээгээр гүйцэтгэж буй ТББ-ын үйл ажиллагаанд мониторинг хийх гэх мэт. Түүнчлэн иргэний нийгмийн үйл ажиллагааны эрх зүйн орчныг бүрдүүлэхтэй холбоотой үйл ажиллагааны гол оролцогч нь Мэргэжлийн холбоод байхаар тусгасан нь оновчтойгүй байна. Иймд нийтийн ашиг сонирхлын тулд, нийгэмд чиглэсэн үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагыг гишүүдийнхээ болон тодорхой бизнесийн эрх ашгийн төлөө ажилладаг мэргэжлийн холбоодоос ялгаатай авч үзэх шаардлагатай байна.

4.1.7.1

Хууль тогтоомжийн тухай хууль хэрэгжиж эхэлснээр хуулийн төслийг цахим хуудсанд байршуулж, олон нийтийн санал авах тогтолцоо нэгэнт бүрдсэн гэж үзэж байна. Тиймээс тогтолцоо шинээр буй болгоно гэхээс илүүтэй одоо байгаа тогтолцоо, хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, үнэлэх ажлыг төрийн бус байгууллагуудтай хамтран зохион байгуулах нь илүү үр дүнтэй юм.

4.1.7.2

1-д Төрийн бус байгууллагын үйл ажиллагаа, санхүүжилтыг ил тод болгох чиглэлээр Төрийн бус байгууллагын тухай хуулийн боловсронгуй болгох гэсэн зорилт дэвшүүлсэн нь авлигыг бууруулах, түүнээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд иргэний нийгмийн хяналт оролцоог нэмэгдүүлэх гэсэн үндсэн зорилготой нийцэхгүй байна. Эсрэгээрээ иргэний нийгмийн чөлөөт үйл ажиллагааг хянах, хумих сөрөг үр дагавар үүсгэх эрсдэлтэй. Иймд иргэний нийгмийн байгууллагын хөгжил, нийгэмд тустай үйл ажиллагаа, тогтвортой хөгжлийг дэмжих, хууль тогтоомжийн хэрэгжилтэд хөндлөнгийн, хараат бус хяналт тавьж, зөрчил

дутагдлыг арилгах чиглэлээр шаардлага, гомдол нэхэмжлэл гаргах, төрийн бодлого, хууль тогтоомж боловсруулах үйл ажиллагаанд оролцох эрхийг нь баталгаажуулах чиглэлээр хууль тогтоомжийг боловсронгуй болгох ажлыг Төлөвлөгөөнд тусгах нь зүйтэй байна.

2-д Хуулийн төслийг олон нийтээр хэлэлцүүлэх нь тогтоомжийн төсөл боловсруулах үйл явцын нэг үе шат болох тул Төрийн бус байгууллагын тухай хуулийн төсөлд иргэний нийгмийн санал авах үйл ажиллагааг энэхүү төлөвлөгөөний 4.1.7.2.1-д заасан хуулийн төсөл боловсруулах үйл ажиллагаатай нэгтгэх нь зүйтэй. Түүнчлэн төрийн бус байгууллагуудыг энэхүү хуулийн төслийг боловсруулах үндсэн оролцогч тал гэж үзэх.

3-д Иргэний нийгмийн ёс зүйн зарчим, хэм хэмжээ нь төрөөс батлагдах бус харин иргэний нийгмийн байгууллагуудын өөрсдийн үүсгэл санаачилгын үндсэн дээр боловсруулагдан батлагдсан, сайн дураар дагаж мөрдөх хэм хэмжээ байх учиртай. Нөгөөтэйгүүр мэргэжлийн холбоод нь хэдийгээр төрийн бус байгууллагын статустай боловч ихэвчлэн зөвхөн гишүүддээ үйлчилдэг буюу гишүүдийнхээ эрх, тодорхой салбарын бизнесийн эрх ашгийг хамгаалах үйл ажиллагаа явуулдаг билээ. Иймд мэргэжлийн холбоодыг иргэний нийгмийн ёс зүйн зарчмыг боловсруулах үйл ажиллагааг хэрэгжүүлэх үндсэн оролцогч тал гэж үзсэнтэй санал нийлэхгүй байна.

4-д Төрийн бус байгууллагууд нь хуулийн дагуу санхүүгийн болон үйл ажиллагааны гэх мэт олон тайланг төрийн холбогдох байгууллагуудад гаргаж өгдөг билээ. Уг тайланд үүсгэн байгуулагч, гишүүдийн мэдээлэл, санхүүжилтын мэдээлэл мөн багтдаг. Иймд нэгэнт хуулиар оногдуулснаас илүү , биелүүлэхэд төвөгтэй, үйл ажиллагаанд нь давхар ачаалал бий болгох бүртгэл, хяналт, тайлагналын үүргийг оногдуулах нь иргэдийн эвлэлдэн нэгдэх эрх болон Хүний эрхийг хамгаалагчдын Тунхаглалд заасан хүний эрхийн төлөөх иргэний нийгмийн байгууллагын эрхийг хязгаарласан хэрэг болно. Иймд энэ үйл ажиллагааг хасах саналтай байна.

4.1.7.3

Төрийн зарим чиг үүргийг гэрээгээр гүйцэтгэж буй төрийн бус байгууллагын үйл ажиллагаанд мониторинг хийх нь иргэний нийгмийн оролцоог нэмэгдүүлэх, тэр дундаа төрийн байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавих боломжийг бүрдүүлэх гэсэн Хөтөлбөрийн зорилготой нийцэхгүй байна. Нөгөөтэйгүүр төрийн зарим чиг үүргийг гэрээгээр гүйцэтгэсэн байгууллага нь үйл ажиллагаагаа холбогдох төрийн байгууллагад тогтмол тайлагнахаас гадна санхүүжилт, түүний зарцуулалтыг Шилэн дансны тухай хуулийн хүрээнд олон нийтэд тайлагнадаг билээ. Иймд Төлөвлөгөөний 4.1.7.3.2д заасан үйл ажиллагааг хасах саналтай байна.

Монгол Улсад улс төрийн санхүүжилтийг Сонгуулийн тухай хууль (сонгуулийн үеийн санхүүжилт), Улс төрийн намын тухай (сонгуулийн бус үеийн санхүүжилт) хоёр хуулиар зохицуулж байна. Үйл ажиллагааны төлөвлөгөөний төсөлд туссан саналууд нь энэ хуулийн хүрээнд зохицуулж буй асуудлуудыг хольж, янз бүрийн дэд зорилтын доор ойлгомжгүй байдлаар тарааж тусгасан байгааг цэгцлэх нь зүйтэй. Түүнчлэн Сонгуулийн тухай хуулийг бүхэлд нь өөрчилж 3 тусдаа хууль боловсруулах асуудлыг тусгасан байгаа нь Улс төрийн санхүүжилтийн ил тод байдлыг хангахтай холбоотой Зорилт 9-тэй уялдахгүй байгааг анхаарна уу. Сонгуулийн процессыг бүхэлд нь зохицуулж буй хууль нь утга агуулгын хувьд энэ зорилтоос хамаагүй өргөн цар хүрээтэй асуудал болно. Үүний оронд Улс төрийн санхүүжилтийг зохицуулсан тусгай хуультай болох талаар судалж, санал боловсруулах ажлыг тусгах зүйтэй гэж үзэж байна.

4.1.9.1

1-д Сонгуулийн зардлын тайлан гаргах тухай одоо хүчин төгөлдөр үйлчилж буй Сонгуулийн тухай хуульд тодорхой зааж хяналт тавих үүргийг Аудитын байгууллагад хариуцуулсан. Гэвч сонгуульд оролцогчдын зүгээс тайлангаа хяналт тавих боломжтой хэлбэрээр буюу нарийвчилсан байдлаар гаргахгүй байгаагийн дээр Аудитын байгууллагад хүлээлгэж өгсөн тайлан нь ил тод биш байдаг. Аудитын зүгээс хүлээж авсан тайлангуудад туссан тоог нэгтгэн ерөнхий статистик маягийн мэдээллийг тайлан болгож олон нийтэд танилцуулж байгаа нь сонгуулийн санхүүжилтийн ил тод байдлыг хангахад огт хангалтгүй юм. Энэ бүх асуудлыг шийдвэрлэх боломжтой байдлаар зорилтоо арай нарийвчлан тусгах нь зүйтэй гэж үзэж байна.

2020 он гэхэд улс төрийн намын санхүүжилтийн тайланг ил тод болгох эрх зүйн зохицуулалтыг бий болгох зорилт дэвшүүлсэн нь сайшаалтай. Гэвч энэ зорилтыг илүү нарийвчлах шаардлагатай гэж үзэж байна. Одоо хүчин төгөлдөр үйлчилж буй Улс төрийн намын тухай хуулийн 20.3. дахь хэсэгт “*Нам санхүүгийн үйл ажиллагаандаа жил бүр аудит хийлгэн баталгаажуулж, нийтэд мэдээлнэ*” гэж заасан байдаг ч ийнхүү мэдээлээгүй тохиолдолд хэнд ямар хариуцлага хүлээх нь тодорхой биш байдгаас огт хэрэгжихгүй байж ирсэн. Энэ нөхцөлд улс төрийн намын санхүүгийн тайланг ямар хөшүүргээр ил тод болгох нь ажлын төлөвлөгөөний төсөлд туссан зорилтоос тодорхой харагдахгүй байна.

2-д Сонгуулиас өмнөх өдөр сонгуулийн санхүүжилтийн тайланг гаргаж ил болгох санал нь сонгуулийн санхүүжилтийн ил тод байдлыг шинэ шатанд гаргахад туйлын ач холбогдолтой зорилт гэж үзэн дэмжиж байна. Улс төрийн намын санхүүжилт, санхүүгийн тайлангийн тухайд олон нийтэд ил тод биш байгаа нь иргэний нийгмийн зүгээс удаа дараа хийсэн мониторингийн тайланд туссан байх тул давхардуулан судлах зорилт дэвшүүлэх шаардлагагүй гэж үзэж байна. Шилэн дансны тухай хууль, Мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хамрах хүрээнд улсын төсвөөс дэмжлэг хүлээж авсан намуудыг багтаан үзэх нь олон улсын стандартад нийцэх бөгөөд үүнийг тодорхой зорилт болгон энэ хэсэгт оруулах саналтай байна.

3-д Сонгуулийн тухай хуульд заасанчлан Сонгуулийн зардлын дансны тайлан болон түүнд хийсэн аудитын дүнг Төрийн аудитын болон Татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад СЕХ-оор дамжуулан өгч байгаа. Ийнхүү тайлагнаагүй тохиолдолд дараагийн сонгуульд нэр дэвших эрхгүй болдог. Үүнээс өөрөөр хариуцлагыг нэмэх бол энэ хэсэгт тодорхой зааж оруулах нь зүйтэй гэж үзэж байна.

4.1.9.2

1-д Сонгуулийн болон сонгуулийн бус үеийн улс төрийн санхүүжилтийн ил тод байдлыг хангахад иргэний нийгмийн хяналт тавих үүрэг оролцоо маш чухал агаад энэ хэсэгт дурдсан үйл ажиллагааг дэмжиж байна.

2,3-д Энд хэрэгжүүлэхээр тусгасан үйл ажиллагаа өмнөх зорилтуудтай давхцсан шинжтэй нэлээд ерөнхий байна. УИХ-д суудалтай намууд нь улсын төсвөөс санхүүгийн дэмжлэг авах тул олон улсын жишгээр санхүүжилт нь олон нийтэд нээлттэй байх ёстой. Цаашид улсын төсвөөс дэмжлэг хүлээн авах нэг нөхцөл нь санхүүгийн тайлангаа хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх болгож зохицуулбал улс төрийн санхүүжилтийн ил тод байдлыг хангах чухал хөшүүрэг болж өгнө.

4.1.9.3

1-д Энд тусгасан байгаа үйл ажиллагаа манай нөхцөлд тохиромжтой эсэх нь эргэлзээтэй. Улс төрийн намд улсын төсвөөс олгох үндэслэлийг өндөрсгөх гэдэг нь “санхүүжилтийг хүртээмжтэй” болгох гэсэн зорилттойгоо зөрчилдөж байгааг тодотгох нь зүйтэй. Үүний оронд олон улсын стандартад нийцүүлэн үндэслэлийг боловсронгуй болгож парламентад суудалгүй намуудад хүртээмжтэй болгоно гэж томъёолбол илүү нийцэлтэй.

2-д Сонгуульд мөрийн хөтөлбөртэй оролцож буй намуудад одоогийн Сонгуулийн тухай хуулиар шууд бус дэмжлэг тэртэй тэргүй үзүүлж байгаа. Үүнээс өөрөө сонгуулийн кампанит ажилд ямар шууд болон шууд бус дэмжлэг төрөөс үзүүлж болохыг судалгаанд үндэслэн, үндэслэлийг оновчтой тодорхойлсны үндсэн дээр тогтоох нь зүйтэй. “Мөрийн хөтөлбөртэй сонгуульд оролцож буй нам” гэсэн нь логикийн хувьд ойлгомжгүй байна. Сонгуульд оролцож байгаа намын бүр заавал мөрийн хөтөлбөртэй байдаг. Үүнийг шалгуур маягаар ийнхүү томъёолох нь огт оновчгүй юм. Угаасаа ямар хэлбэрийн дэмжлэгийг сонгуульд оролцож буй талуудад үзүүлэх гэдэг нь судалгаа шинжилгээ хийж ул суурьтай шийдэх ёстой асуудал болно. Сонгуулийн тогтолцоо мажоритар байгаа тохиолдолд намууд гэхээсээ илүү нэр дэвшигчдэд хандсан дэмжлэг ч илүү үр дүнтэй байж болохыг онцолж байна.

3-д Энэ хэсэгт сонгуульд оролцож буй талуудад үзүүлэх “шууд бус” санхүүжилтийг авч үзэж байна гэж ойлгогдож байна. Энэ асуудлыг мөн өмнө дурдсанчлан юуны өмнө нухацтай судалж, намууд зөвшилцөж шийдвэрлэх асуудал болохыг онцолж байна.

4.1.9.4

		<p>1-д Сонгуулийн тухай хууль нь хэрэгжиж эхлээд удаагүй байна. Энэ хуулийг сонгуулийн төрөл тус бүрээр буцаан салгах үндэслэлийг оролцогч талууд ул суурьтай ярилцаж зөвшилцөөгүй нөхцөлд ийм үйл ажиллагаа хэрэгжүүлэхээр төлөвлөгөөнд тусгах нь оновчгүй гэж үзэж байна. Түүнчлэн сонгуулийг зохион байгуулахтай холбоотой ерөнхий хууль нь Авлигатай тэмцэх хөтөлбөрийн Зорилт 9 буюу улс төрийн санхүүжилтийг ил тод болгох гэсэн буюу энэ хэсгийн ерөнхий зорилгоос илүү том цар хүрээтэй асуудал болохыг сануулах нь зүйтэй.</p> <p>2-д 4.1.9.1-ийн 2-т тусгасантай давхцаж байна.</p> <p>3-д Энд тусгасан үйл ажиллагаа нь сонгуулийн санхүүжилтийг ил тод болгох зорилттой хэрхэн уялдах нь огт ойлгомжгүй байгааг анхаарна уу.</p> <p>4-д Хууль зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлагыг нэмэгдүүлэх нь зүйтэй боловч хууль хэрэгжихгүй байгаа гол шалтгаан нь хяналт сул байгаа явдал болохыг анхааралдаа авч энэ хяналтыг хэн хэрхэн хэрэгжүүлэх талаар илүү нарийвчлан хуульд тусгах зорилт тавих нь оновчтой гэж үзэж байна.</p> <p>7-д Сонгуулийн тухай хуульд сонгуулийн тайланд Аудит, Татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага тус тус хяналт тавихаар тусгасан одоогийн нөхцөлд хамгийн тохиромжтой хувилбар гэж оролцогч талууд үндсэндээ санал нийлж буй билээ. Энэ нөхцөлд “хяналт тавих эрх бүхий байгууллагын талаар санал цуглуулах” гэсэн байгаа нь ойлгомжгүй байна. Үүний оронд Аудит болон Татварын асуудал эрхэлсэн байгууллагууд яг ямар асуудал дээр хяналт тавьж дүгнэлт гарган нийтэд танилцуулах тухай илүү нарийвчлан хуульд тусгавал үр дүнтэй гэж үзэж байна.</p>
37.	Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхим	Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний төсөл болон түүнийг батлах Засгийн газрын тогтоолын төслийг хүлээн авч, танилцсан бөгөөд ямар нэг саналгүй болохоо үүгээр мэдэгдэж байна.
38.	Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбоо	<p>Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний төсөл болон түүнийг батлах Засгийн газрын тогтоолын төслийг дэмжиж байна. Үүнээс гадна дараахь 2 үйл ажиллагаанд хамтран оролцох хүсэлтэй байгаа тул төлөвлөгөөндөө тусгаж өгөхийг хүсье. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Төлөвлөгөөний төслийн 4.1.6.2-н 1-д тусгагдсан “Хувийн хэвшлийн байгууллагуудыг чадавхижуулах цогц сургалтыг үе шаттайгаар зохион байгуулах”-ад хэрэгжүүлэгч байгууллагууд дээр МАОЭНХ гэж нэмж оруулах 2. Төлөвлөгөөний төслийн 4.1.6.3-н 1-д “төр, хувийн хэвшлийн зөвлөлдөх уулзалтыг бизнесийн чиглэл, салбар бүрээр зохион явуулах”-ад хэрэгжүүлэгч байгууллагууд дээр МАОЭНХ гэж нэмж оруулах.
39.	Монголын бизнесийн зөвлөл	Төсөлд нэмж санал оруулах зүйлгүй.
40.	Монголын хуульчдын холбоо	<p>“Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний төсөл батлах тухай” Засгийн газрын тогтоолын төсөлтэй танилцаад зарчмын хувьд дэмжиж дараахь саналуудыг хүргүүлж байна.</p> <ol style="list-style-type: none"> 1. АТҮХ-г хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний төслийн 4.1.5.1-н 3-т заасан Шүүгчид нэр дэвшигчийг Монгол Улсын Ерөнхийлөгч шүүгчээр томилохоос татгалзах шийвэрт үндэслэлээ заах ёстой. Учир нь Шүүхийн ерөнхий зөвлөлөөс тодорхой дүрэм журмын дагуу сонгон шалгаруулалтаар сонгогдож шалгарсан хуульчийг Ерөнхийлөгч томилохоос татгалзах нь маш тодорхой үндэслэлтэй байх шаардлагатай. Нөгөө талаас Ерөнхийлөгч шүүгчийг томилж байгаа нь шүүгчийн хараат бус байдлын баталгаа болох үзэл баримтлалыг хууль тогтоомжид суулгах. 2. Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 3.1.3 дахь заалт хүчингүй болсонтой холбогдуулан хуульчийн мэргэжлийн ажиллагааны төрөл, хугацааг хууль хэрэглэгчид зөрүүтэй ойлгон хэрэглэж байгаа нь хуульчдын эрх ашиг, сонирхлыг зөрчиж байна. Иймд тус ойлголтыг практикт нэг мөр ойлгон хэрэглэх ажил зохион байгуулахыг тусгах;

		<p>3. Шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдлын баталгааг хангах. Тухайлбал, жил бүр улсын төсөв батлагдах үед шүүгчийн цалингийн асуудал хөндөгддөг байдлыг халах. Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 28.5-д “Шүүхийн үйл ажиллагааны төсвийг өмнөх жилийнхээс бууруулахыг хориглоно.” гэсэн заалтыг хүчингүй болгосныг сэргээх, цаашлаад шүүгчийн цалин улсын төсвийн тодорхой хувь байх зохицуулалтыг хуульд тусгах;</p> <p>4. Шүүгчийн нийгмийн хамгааллын асуудалд анхаарах хүрээнд Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 24.7-д “Шүүгчээр нийт 25 жил ажилласан шүүгч өөрөө хүсвэл өндөр насны тэтгэвэр тогтоолгож болно.” гэх заалтын хэрэгжилтийг хангах. Дагалдаж нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 6-д “...25 жил шүүгчээр ажилласан даатгуулагч өөрөө хүсвэл нас харгалзахгүйгээр өндөр насны тэтгэвэр тогтоолгон авах эрхтэй.” гэж нэмж тусгах саналтай байна.</p>
--	--	--

-oOo-